

МОНГОЛ УЛСЫН ШАШНЫ НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ДҮГНЭСЭН ОЛОН УЛСЫН ШАШНЫ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТАЙЛАНГ ШИНЖЛЭХ НЬ

С.Янжинсүрэн (Ph.D)

Философи, шашин судлалын тэнхим.

ШУС. МУИС

Түлхүүр үгс: Төр, сүм хийдийн харилцаа, шашны байгууллага, шашин шүтэх, эс шүтэх эрх, шашны эрх чөлөө, олон улсын шашны эрх чөлөөний тайлан

Товч утга: Шашин бол хүн төрөлхтний нийгэм, соёл, оюун санааны амьдралд хамгийн урт хугацаанд хамт байж ирсэн үзэгдэл ба тэр хэрээрээ хамгийн түгээмэл, тодорхой асуудал байх байтал харин ч тодорхойлоход төвөгтэй, эмзэг, зарим талаар далд, олон талтай үзэгдэл болж хөгжсөн байна. Тиймээс улс бүр шашны нөхцөл байдлаа эмх цэгцтэй, гэхдээ эрх чөлөөтэй байлгахыг эрмэлзэж төр, сүм хийдийн харилцаа, шашин шүтлэгийн эрх зүйн орчноо бүрдүүлэхэд анхаарч иржээ.

Шашин шүтэх, эс шүтэх эрх бол Монгол Улсын хувьд “Онц болон дайны байдал” зарласан ч үл хөндөгддөг¹, хүний салшгүй эрх байдаг бөгөөд Монгол Улсад олон шашны 70 шахам урсгал, чиглэл ямар нэг хориг саадгүйгээр чөлөөтэй үйл ажиллагаа явуулж байгаа нь Монгол Улсад шашин, шүтлэг хоёр “чөлөөтэй” байгаагийн нотолгоо болно.

Улс орнууд ард түмнүүдийн сүсэг бишрэлд холбогдох асуудлыг сонирхож, үзэл бодлоо илэрхийлж ирсэн онцлогтой.

АНУ гадаад бодлогодоо шашны эрх чөлөөг дэмжих зарчим баримталдаг ба ингэхдээ 1998 онд Олон улсын шашны эрх чөлөөний актыг батлан мөрдөж эхэлжээ. Түүнээс хойш жил бүр дэлхийн улс орнуудын шашны нөхцөл байдлыг дүгнэсэн тайланг боловсруулж, олон нийтэд нээлттэй нийтэлж хэвшсэн бөгөөд тэдгээрийг нийтэд нь “Олон улсын шашны эрх чөлөөний тайлан” гэж албан ёсоор нэрлэдэг.

Түүнчлэн АНУ-ын Төрийн департаментаас Монгол Улсын шашны эрх чөлөөний тайланг тэрхүү Олон улсын шашны эрх чөлөөний тайлангийн хүрээнд боловсруулж жил бүр олон нийтэд нээлттэй нийтэлдэг.

Тус өгүүлэлд Монгол Улсад холбогдох 2015, 2016, 2017, 2018 онуудын тайлангийн агуулгыг авч үзсэн болно.

* * * * *

Монгол Улс нь өөрийн нутаг дэвсгэрт хууль ёсоор оршин суугаа хүн бүрийг шашин шүтэх, эс шүтэх эрхээр хангасан²; төр, сүм хийдийн харилцаа нь төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдлэх зарчимд үндэслэсэн³; ард түмнийхээ эв нэгдэл, соёл иргэншлийн түүхэн уламжлалаа эрхэмлэхийн үүднээс Монгол Улс дахь буддын шашны зонхилох байр суурийг хүндэтгэдэг⁴; хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс,

¹ Монгол Улсын Үндсэн хуулийн 19.2

² Монгол Улсын Үндсэн хууль, Арван зургадугаар зүйлийн 15.

³ Монгол Улсын Үндсэн хууль, Есдүгээр зүйлийн 1; Төр сүм хийдийн харилцааны тухай хууль, дөрөвдүгээр зүйлийн 1.

⁴ Монгол Улсын Төр, сүм хийдийн харилцааны хууль, дөрөвдүгээр зүйлийн 2.

нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварладаггүй¹ товчдоо бол шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй улс мөн болно.

Шашин шүтэх, эс шүтэх эрх бол Монгол Улсын хувьд “Онц болон дайны байдал” зарласан ч үл хөндөгддөг², хүний салшгүй эрх байдаг.

Монгол Улсад олон шашны 70 шахам урсгал, чиглэл үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн дотор олон улсад, нийгэмд хор хөнөөл учруулж болзошгүй шашны урсгалуудад тооцогдож хориглогдсон, эсвэл тийм жагсаалтад орсон шашны урсгалууд ч ямар нэг хориг саадгүйгээр чөлөөтэй үйл ажиллагаа явуулж байгаа нь Монгол Улсад шашин, шүтлэг хоёр “чөлөөтэй” байгаагийн нотолгоо болно. Монгол Улсын албан ёсны статистикийн мэдээгээр улсын хэмжээнд 364 сүм хийд, 1552 санваартан, 612 шашны сургуульд суралцагч³ байна.

1921 оны хувьсгалаас хойш өнөөг хүртэл Монголын төрөөс төр, сүм хийдийн харилцаа, шашин шүтлэгийн эрх зүйн орчныг бүрдүүлэхдээ 4 Үндсэн хууль (1924, 1940, 1960, 1992)-иас гадна “Монгол улсын төр, шашны хэргийг тусгаарлан явуулах тухай дүрэм” (1926, 2 бүлэг 14 зүйл), “Төр, шашныг тусгаарлан явуулах тухай хууль” (1934, 8 бүлэг 35 зүйл), “Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль” (1993, 4 бүлэг, 13 зүйл) гэсэн төр, сүм хийдийн харилцааг зохицуулсан нэг дүрэм, хоёр хуулийг батлан мөрдүүлжээ.

Улс орнууд ард түмнүүдийн сүсэг бишрэлд холбогдох асуудлыг сонирхож, үзэл бодлоо илэрхийлж иржээ. Тухайлбал, АНУ гадаад бодлогодоо шашны эрх чөлөөг дэмжих зарчим баримталдаг ба ингэхдээ 1998 онд Олон улсын шашны эрх чөлөөний актыг батлан, мөрдөж эхэлжээ⁴. Түүнээс хойш жил бүр дэлхийн улс орнуудийн шашны нөхцөл байдлыг дүгнэсэн тайланг боловсруулж, нээлттэй нийтэлж хэвшсэн бөгөөд тэдгээрийг “Олон улсын шашны эрх чөлөөний тайлан” гэж албан ёсоор нэрлэдэг.

АНУ-ын Төрийн департамент Олон улсын шашны эрх чөлөөний тайлангийн хүрээнд Монгол Улсын шашны эрх чөлөөний тайланг жил бүр бичиж, түүнд Монгол улсын шашны нөхцөл байдал, шашны хууль эрх зүйн орчин, шашны практик амьдралд тохиолдож байгаа асуудлуудын талаар дэлгэрэнгүй авч үзэж, үнэлэлт дүгнэлт, санал шүүмж өгч ирсэн нь шашиныг сонирхдог хүн бүр зүй ёсоор анхаарч үзэх сэдэв мөн юм.

Олон улс өөрт нь хамаарах ийм тайлангуудад тухайлбал, БНЭУ энэ талаар өөрийн байр суурийг илэрхийлэхдээ, манай улс ардчилсан улс бөгөөд шашны эрх чөлөөг Үндсэн хуулиараа баталгаажуулсан байдаг юм, гадаадын аль нэг улс манай улсын иргэний шашны эрх чөлөөний талаар дүгнэлт хийхийг бид зөвшөөрөхгүй⁵; БНХАУ манай улсын дотоод асуудалд хөндлөнгөөс оролцохоо болих хэрэгтэй, Хятад улс иргэдийнхээ шашин шүтлэгийн эрх чөлөөг хуулиараа хамгаалдаг юм⁶; БНТУ-ын ГХЯ-ны ажилтан Хами Аксоу 2015 оны 5 дугаар сарын 30-нд АНУ олон улсын шашны эрх чөлөөний тайландаа Туркийг үндэслэлгүйгээр шүүмжилсэн гэж мэдэгдсэн ба тэрээр манай шашны нөхцөл байдал илт

¹ Монгол Улсын Үндсэн хууль, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь заалт.

² Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 2.

³ 1212.mn

⁴ <http://www.congress.gov.house-bill>

⁵ <https://religionunplugged.com/news/2019/6/21/five-takeaways-from-the-2018-international-religious-freedom-report>

⁶ https://www.chinadaily.com.cn/china/2015-10/15/content_22199438.htm

дээрдсэн¹ хэмээжээ. Мөн Исламын Бүгд Найрамдах Пакистан Улс “... Америкийн Нэгдсэн Улсын төрийн департамент Олон улсын шашны эрх чөлөөний тайланг нотлогдоогүй баримтуудад үндэслэн гаргаж байна”²; Израилын Гадаад хэргийн яамны ажилтан Америкийн Нэгдсэн Улс, Израиль хоёр нь хоёр өөр систем юм, үүнийг харгалзахгүйгээр тайлан гаргаж байна³ хэмээсэн бол Ираны ГХЯ-ны ажилтан Бахрам Гхасеми бээр Ираныг улс төрийн зорилгоор үндэслэлгүй шүүмжилж байна, АНУ өөрийнхөө дотоод дахь ялгаварлалын асуудлаа цэгцлэх хэрэгтэй, ялангуяа Мусульманчуудаа ялгаварлахаа боль⁴ хэмээсэн гэж цахим эх сурвалжууд мэдээлжээ.

Олон Улсын шашны эрх чөлөөний тайлангийн Монгол Улсад холбогдох тайлан нь:

Нэгдсэн хураангуй,

I хэсэг. Шашны хүн ам зүй

II хэсэг. Шашны эрх чөлөөнд хандах засгийн газрын байр суурь,

Хууль эрх зүйн хүрээ

Засгийн газрын үйл ажиллагаа

III хэсэг. Шашны эрх чөлөөнд хандах нийгмийн хандлага

IV хэсэг. АНУ-ын Засгийн газрын бодлого гэсэн бүтэцтэй юм.

Тайлангийн хураангуй нь бүхэлдээ (2015) “Монгол улсын Үндсэн хуульд “шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг” Монгол улсын иргэний үндсэн эрх хэмээн тунхаглаад төр, шашны үйл ажиллагаа тусдаа байх ёстойг заасан. Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулиар шашны байгууллагууд төрийн байгууллагад бүртгүүлэх шаардлагатай бөгөөд холбогдох журмыг дэлгэрэнгүй хуульчилсан ч хэрэгжилттэй холбоотой нарийвчилсан журмыг орон нутгийн эрх баригчдын мэдэлд үлдээсэн. Бүртгэлийн үйл явц улсын хэмжээнд харилцан адилгүй байдаг. Зарим нэг шашны бүлэг шинээр бүртгүүлэх, бүртгэлээ сунгуулахад орон нутгийн эрх баригчдын зүгээс бэрхшээлтэй тулгарсан гэдгээ мэдэгдсэн. Шашны үйл ажиллагаа эрхлэх хүсэлтэй гадаадын иргэн шашны виз авах ёстой ба ийм үйл ажиллагаа эрхлэх Монгол иргэний хувьд тусгайлсан журам байхгүй. Буддын шашны тэргүүнүүд Далай ламыг Монгол улсад айлчлахыг урьсаар байгаа боловч 2011 оноос хойш засгийн газар түүний айлчлалыг зөвшөөрөхгүй байгаа.

Христийн шашныхныг гадуурхах, зүй бус харьцсан гэх тохиолдлууд мэр сэр бүртгэгдсэн ч тэдний нийгмийн сайн сайхны төлөө хийж байгаа буяны ажлууд олон нийтэд Христийн шашны талаар эерэг сэтгэгдэл төрүүлэхэд нөлөөлж байгаа гэж Христийн шашны тэргүүнүүд үзэж байна.

АНУ-ын Элчин сайдын яамны ажилтнууд шашны эрх чөлөөний асуудлаар бүх түвшинд төр засгийн албаны хүмүүстэй уулзаж ярилцсаны дотор Ерөнхийлөгчийн Тамгын газар, Гадаад Харилцааны Яам, УИХ, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал зэрэг өндөр албан тушаалын хүмүүс багтсан байна. Элчин сайдын яамны ажилтнууд мөн шашны тэргүүнүүдтэй тогтмол уулзаж, шашны эрх чөлөөний асуудлаар ярилцдаг”⁵ хэмээн 2015 оны Монголын шашны эрх чөлөөний тайланг хураангуйлсан байна.

¹ <https://www.hurriyetdailynews.com/turkey-slams-us-report-on-religious-freedom-132643>

² https://www.xinhuanet.com/english/2019-06/29/c_138183172.htm

³ <https://www.timesofisrael.com/israel-pushes-back-on-us-report-spotlighting-religious-freedom-woes/>

⁴ <https://www.millenniumpost.in/world/china-iran-reject-us-religious-freedom-report-as-hypocritical-257749>

⁵ <https://mn.usembassy.gov/our-relationship/official-reports/2015-international-religious-freedom-report/>

2016 оны тайлангийн нэгдсэн хураангуйгаас 2015 оныхтой давхардсан хэсгийг ялгавал дараах байдалтай байна. Үүнд: “Аймаг болгонд бүртгэлийн журам харилцан адилгүй байдаг, бүртгэлийн ажилтан солигдсон, шашны салбар байгууллагыг бүртгэхэд гардаг хуулийн хязгаарлалт зэрэг шалтгаанаас үүдээд зарим шашны бүлэг шинээр бүртгүүлэх, бүртгэлээ сунгуулахад орон нутгийн эрх баригчдын зүгээс бэрхшээлтэй тулгарсан гэдгийг мэдэгдсэн. Шинээр шашны байгууллагыг огт бүртгэдэггүй, эсвэл бүртгэлийг хэдэн жилээр сунжруулдаг зарим аймаг байдаг. Бүртгэлгүй шашны байгууллагуудад татварын алба, цагдаа зэрэг төрийн байгууллагынхан шалгалтаар ирж, хахууль эсвэл тодорхой хуулийн үндэслэлгүйгээр бичиг баримт шаардах тохиолдол гарсан гэдгийг зарим шашны байгууллагууд хэлж байв. Шашны үйл ажиллагаа эрхлэх хүсэлтэй гадаадын иргэн шашны виз авах ёстой ба ийм үйл ажиллагаа эрхлэх Монгол иргэний хувьд тусгайлсан журам байхгүй. Энэ оны 11-р сарын 18-23-ны өдрүүдэд Далай лам Монгол улсад айлчилсан. Энэ айлчлалаас шалтгаалж Хятадын засгийн газар хэлэлцэж байсан зээлээ өгөхөө болино хэмээн сүрдүүлсний дараа 12-р сард Монгол улсын гадаад хэргийн сайд Далай ламын айлчлал хоёр улсын харилцаанд сөргөөр нөлөөлсөнд Монгол улсын засгийн газар харамсаж буйг илэрхийлээд өөрсдийн засаг барих хугацаанд Далай ламыг дахин айлчлуулахгүй гэдгийг амласан. Бөөгийн шашны тэргүүн засгийн газар бусад шашнуудад үзүүлдэг татвар болон санхүүгийн хөнгөлөлтийг бөөгийн шашинд адилхан эдлүүлдэггүй гэдгийг хэлж байв.

Шашны цөөнхийг дарамталсан талаар мэдээлэл ирж байв. Дэлхийн энх тайван, эв нэгдлийн төлөөх гэр бүлийн холбоо (Эв нэгдлийн сүм)-ны үйл ажиллагааны талаарх видео бичлэг YouTube дээр гарсантай холбогдуулж, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны нэгэн газрын даргад дарамт учирч, улмаар ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлт гаргасан. Гэхдээ ажлаа үргэлжлүүлэн хийсэн болно. Түүнийг Эв нэгдлийн сүмд зориулж мөнгө угаасан, хүүхэд залуучуудын тархийг угаасан гэх үндэслэлээр шалгахыг Авлигатай тэмцэх газраас шаардаж байв”¹ хэмээн манай улсын шашинтай холбогдох үйл явдлуудыг хураангуйлан бичсэн байна.

2017 оны нэгдсэн хураангуйгаас 2015, 2016 оныхтой давхардсан хэсгийг ялгавал шашинд холбогдох тус оны онцлох үйл явдлууд дараах байдалтай байна. Үүнд: “7-р сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн Эрүүгийн шинэчлэн найруулсан хуулинд шашин шүтэх, эс шүтэх эрхийг хэрэгжүүлэхэд саад учруулахыг хориглох болон шашны байгууллага, шашны төлөөлөгч, номлол түгээгч өөрийн шашны үзэл номлолоо бусад хүчээр тулгах, шахалт үзүүлэх, хууран мэхэлж татан оруулах, эсхүл шашны харгис үзэл номлолыг сурталчлахыг хориглосон заалтууд орсон. Мөн 7-р сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн шинэчлэн найруулсан Зөрчлийн тухай хуулинд хувь хүн, хуулийн этгээд хүүхдийн хүсэл зоригийн эсрэг шашны үйл ажиллагаанд татан оролцуулах, иргэний шашин шүтлэгийн байдлыг уг хүн өөрөө хүссэнээс бусад тохиолдолд албан баримт бичигт тусгах болон хуульд зааснаас бусад тохиолдолд сүм хийдийн дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцох зэргийг хориглосон. Дээрх хуулиудад торгууль, шийтгэлийн хэмжээг өмнөхөөс ихэсгэсэн. Шашны байгууллага улс төрийн үйл ажиллагаа явуулах, санхүүжүүлэх мөн төрийн харьяалал бүхий сургууль, байгууллагад шашны сургалт, цугларалт зохион байгуулах нь хуулиар хориотой.

¹ <https://mn.usembassy.gov/our-relationship/official-reports/2016-international-religious-freedom-report/>

Нэгдүгээр сард Элчин сайд залуу удирдагчдын төлөөллийг өргөөндөө урьж, шашны эрх чөлөөний талаар чөлөөт ярилцлага өрнүүлсэн. 9-р сард Элчин сайдын яам будда, христ, бөө, мусульман зэрэг шашны удирдагчидтай дугуй ширээний уулзалт хийж, шашны эрх чөлөөг хэрхэн хүндэтгэх, шашин хоорондын харилцааг хэрхэн бий болгох талаар ярилцсан. Элчин сайдын яам мөн шашны эрх чөлөөг нийгмийн сүлжээгээр дэмжсэн”¹ гэжээ.

2018 оны тайлангийн хураангуйгаас өмнөх онуудын тайланд давхардсныг ялгаж онцлох үйл явдлуудыг үлдээвэл дараах байдалтай байна. Үүнд: Монгол Улсад “...шашин шүтэх, эс шүтэх эрхийг хэрэгжүүлэхэд саад учруулахыг хуулиар хориглосон ч шашинд элсүүлэх зохицуулалт хязгаарлагдмал. Шашны байгууллага засгийн газрын болон улс төрийн үйл ажиллагаанд оролцох, төрийн харьяалал бүхий сургууль, байгууллагад шашны сургалт, цугларалт зохион байгуулах, мөн хүүхдийн хүсэл зоригийн эсрэг шашны үйл ажиллагаанд татан оролцуулах зэрэг нь хуулиар хориотой. “...Засгийн газар бүртгэлийн асуудал зэргийг зохицуулсан шашин шүтэх эрх чөлөөний талаарх хуулийг шинээр боловсруулсан ба үүнд олон нийтийн саналыг авсан. “Зарим орон нутгийн удирдлага олон жил шашны байгууллагыг шинээр бүртгэхгүй байгаа мэдээлэл байна. Нэгэн христийн байгууллагын хэлснээр нийслэлийн захиргааны нэг ажилтан хэт олон христийн байгууллага бүртгүүлсэн байгаа гэсэн шалтгаанаар тэдний байгууллагыг бүртгэхээс татгалзсан байв... 7-р сард Вашингтон хотод болсон “Шашны эрх чөлөөг дэмжих сайд нарын хурал”-д оролцсоныхоо дараа гадаад харилцааны сайд шашны эрх чөлөөний асуудал хариуцсан тусгай үүрэг гүйцэтгэгч элчин сайдын орон тоог бий болгосон.

Христ, мусульман шашинтнууд болон бусад шашны цөөнхийг нийгмийн сүлжээгээр дарамталсан талаар мэдээлэл ирж байв. Жишээлбэл, нэгэн христийн сүмийн адис хүртээх ёслолын зураг Facebook дээр тавигдсан нь олон сөрөг сэтгэгдэл хүлээж авчээ... 7-р сард АНУ-ын Олон улсын шашны эрх чөлөөний асуудал хариуцсан тусгай үүрэг гүйцэтгэгч элчин сайд Гадаад харилцааны сайдтай уулзаж, шашны эрх чөлөөний хуулийг сайжруулах явдлыг дэмжсэн. 10-р сард тусгай үүрэг гүйцэтгэгч элчин сайд шинээр томилогдсон Монгол Улсын тусгай үүрэг гүйцэтгэгч элчин сайдтай уулзаж, хамтын ажиллагааны боломжийн талаар ярилцсан... Олон улсын шашны эрх чөлөөний өдөрт зориулан хэд хэдэн шашны залуу төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлгийг Элчин сайдын яам 1-р сард зохион байгуулсан ба шашин хоорондын яриа хэлэлцээг нэмэгдүүлэх, өөр шашин, шашингүйн үзлийг хүлцэх талаар чөлөөт ярилцлага өрнүүлсэн”² гэх зэргээр тайлан тус бүрийн өмнө нэгдсэн хураангуй оруулжээ.

Монголын тайлангийн (2015) хүн амзүйн хэсэгт “АНУ-ын Засгийн газрын тооцоолсноор Монгол улсын нийт хүн ам 3 сая (2015 оны 7-р сарын байдлаар). Хамгийн сүүлийн хүн амын нэгдсэн тооллого 2010 онд хийгджээ. 15-аас дээш насны хүн амын 53 хувь өөрсдийгөө Буддын шашинтан гэж тодорхойлсон бол 3 хувь нь Мусульман, 2.9 хувь нь Бөө, 2.1 хувь нь Христийн шашинтан гэжээ. 38.6 хувь нь өөрсдийгөө шашин шүтдэггүй гэж тодорхойлсон байна. Олон хүн бөөгийн шашны зан үйлийг өөр шашинтай, тухайлбал Буддын шашинтай хослуулж хийдэг. Христийн шашинтнуудын дийлэнх нь Протестант

¹ <https://mn.usembassy.gov/our-relationship/official-reports/2017-international-religious-freedom-report/>

² <https://mn.usembassy.gov/our-relationship/official-reports/2018-international-religious-freedom-report/>

урсгалынхан ба үлдсэн нь Есүс Христийн Хожмын үеийн гэгээнтнүүдийн сүм (Мормон), Католик болон Оросын Үнэн алдартны шашны урсгалынхан болно”¹ хэмээсэн байна. Энд Үндэсний статистикийн хорооноос хэрэгжүүлсэн “Хүн ам орон сууцны 2010 оны улсын тооллого”-ын дүнг ашигласан бөгөөд бусад шашин хүн амын 0.4 хувь шүтдэг² тухай статистикийг л үлдээснээс бусдыг бүрэн тусгажээ.

Мөн оны тайланд “...Христийн шашинтнуудын дийлэнх нь Протестант урсгалынхан ба үлдсэн нь Есүс Христийн Хожмын үеийн гэгээнтнүүдийн сүм (Мормон), Католик болон Оросын Үнэн алдартны шашны урсгалынхан болно.” гэсэн бол 2016 оны тайланд дээрхээс гадна “Дэлхийн энх тайван, эв нэгдлийн төлөөх гэр бүлийн холбоо (Эв нэгдлийн сүм) гэх зэрэг шашны бүлгүүд мөн бий. Монгол улсын баруун хойно амьдардаг казахуудын ихэнх нь мусульман шашинтан болно.”³ гэжээ.

2017 оны тайланд “...Роман католик болон Ёховагийн гэрчүүд шашны урсгал байгаа талаар, **2018 оны тайланд** “Ерөнхийлөгчийн Соёл, шашны бодлогын зөвлөхийн хэлснээр, Монголын буддистуудын ихэнх нь Махаяна урсгалыг шүтдэг... Христийн шашинтнуудын дийлэнх нь протестант урсгалынхан ба үлдсэн нь Есүс Христийн хожмын үеийн гэгээнтнүүдийн сүм, Роман католик, Ёховагийн гэрчүүд болон Оросын үнэн алдартны шашны урсгалынхан болно. Монголын Бахайн нийгэмлэг, Дэлхийн энх тайван, эв нэгдлийн төлөөх гэр бүлийн холбоо (Эв нэгдлийн сүм) гэх зэрэг шашны бүлгүүд мөн бий”⁴ хэмээн тус тус нарийн бүртгэжээ.

Шашны эрх чөлөөнд хандах засгийн газрын байр суурь хэмээх II дахь хэсэгт: 2015 оны тайлангийн тус хэсэгт Монгол Улсын Үндсэн хууль, Төр сүм хийдийн харилцааны тухай, Боловсролын тухай, Хөдөлмөрийн тухай, Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай зэрэг хууль тогтоомж дахь шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, төр сүм хийдийн харилцааны талаарх хуулийн зохицуулалтуудыг дэлгэрэнгүй тоочсон байх ба шашны байгууллагын бүртгэлийн талаарх эрх зүйн орчинд илүүтэй анхаарчээ.

Энэ хэсэгт нийслэл болон зарим аймгийн шашны байгууллагыг бүртгэх асуудлын талаар тодорхой дурдсан байна. Тухайлбал, “Төв аймагт 2 буддын шашны хийд байдаг ба 2011 онд энэ тоо 6 байжээ”, “Дархан уул аймагт ... мусульманы хоёр сүмийг бүртгээгүй байсан. Тэд бүртгүүлэх өргөдлөө 2013 оны сүүлчээр өгсөн хэдий ч бүртгэлгүйгээр үйл ажиллагаа хэвийн явуулж болж байгаа”; “Монголын Эвангелийн эвслийн мэдээлснээр ... Дорноговь аймаг дахь тэдний гишүүн сүмүүдийн нэг нь ч бүртгүүлэх болон бүртгэлээ сунгуулж чадахгүй байгаа ба үүнийг Дорноговь аймгийн газар нутагт Буддын шашны чухал дурсгалт газар болох Хамрын хийд оршдог онцлогтой холбон тайлбарлаж байна”⁵ (2015) гэжээ.

Мөн энэ хэсэгт “Төр засгийн зүгээс шашин, түүх, соёлын чухал төвүүд гэж үзсэн Буддын шашны газруудыг сэргээн засварлахад хөрөнгө зарцуулсан. Төрөөс бусад шашны бүлэгт татаас өгсөн тохиолдол гараагүй.” (2015, 2016, 2017, 2018) “Хэдийгээр орон нутгийн татварын байцаагчид, цагдаагийнхан болон бусад эрх бүхий байгууллагаас байн

¹ <https://mn.usembassy.gov/our-relationship/official-reports/2015-international-religious-freedom-report/>

² Хүн ам орон сууцны 2010 оны улсын тооллогын нэгдсэн дүн. Үндэсний статистикийн хороо, УБ., 2010, 61 дэх талд.

³ <https://mn.usembassy.gov/our-relationship/official-reports/2015-international-religious-freedom-report/>

⁴ <https://mn.usembassy.gov/our-relationship/official-reports/2018-international-religious-freedom-report/>

⁵ <https://mn.usembassy.gov/our-relationship/official-reports/2015-international-religious-freedom-report/>

байн шалгалт хийж, дарамт учруулдаг ч бүртгэлгүй шашны байгууллагууд бодит байдал дээр үйл ажиллагаа явуулах боломжтой байдаг.”¹ (2015) гээд “Зарим сүм хийдийнхэн орон нутгийн улирдлага тухайн орон нутгийн захиргаа болон нутгийн хүмүүст хэрэгтэй ямар нэг “төсөл” хэрэгжүүлсний дараа л бүртгэлийг сунгах албан бичиг өгдөг тухай хэлж байв. Нэгэн шашны бүлэгт орон нутгийн захиргаанаас явган хүний болон авто зам засах хүсэлт ирсэн тухай мэдэгдсэн”² (2016) гэжээ.

Түүнчлэн “Хууль зүйн сайд 3-р сард шашны байгууллагуудын тоо болон тэдний үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг тодорхойлох зорилгоор ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсгийнхний хэвлэл, мэдээлэлд өгсөн ярилцлагадаа шашны байгууллагуудын нэгдсэн мэдээллийн бааз байгуулах мөн цагдаа, тагнуул, татвар, даатгалын зэрэг байгууллагууд шашны байгууллагуудын орлого, санхүүгийн эх үүсвэрийг сайтар шалгаж тодруулах хэрэгтэй байгааг хэлсэн”³ (2016) бөгөөд “2016 онд Хууль зүйн сайд шашны байгууллагуудын тоо болон тэдний үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг тодорхойлох зорилгоор ажлын хэсэг байгуулсан ба тэд үүрэгт ажлаа дуусгасан. Ажлын хэсгийнхний дүгнэлтийг олон нийтэд танилцуулаагүй”⁴ (2017) гэжээ.

Гэтэл 2018 оны тайланд “2016 онд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хийсэн шалгалтаас харвал, улсын хэмжээнд 848 шашны байгууллага (54.2% нь христ, 34.6% нь будда, 5.1% нь мусульман, 6% нь бусад шашны байгууллага) үйл ажиллагаа явуулж буйн 352 нь албан ёсны бүртгэлгүй үйл ажиллагаа явуулж байна.”⁵ гэсэн байна.

Тайлангийн III хэсэг буюу Шашны эрх чөлөөнд хандах нийгмийн хандлагын талаар дараах байдлаар бичжээ. Үүнд: “...Христийн шашны удирдагчдын мэдээлж байгаагаар тэдний хийж буй буяны ажил үйлс олон нийтэд хүлээн зөвшөөрөгдөхийн хэрээр Христийн шашныг улам бүр нааштай хүлээж авах болсон”⁶(2015), “...нөгөө талдаа тус улсад христийн шашны нөлөө улам ихсэж байгаа нь сэтгэл түгшээж байгаа тухай буддын болон мусульман шашны зарим удирдагч мэдэгдсэн”⁷ (2016), “...сэтгүүлч Л.Мөнхбаясгалан Эв нэгдлийн сүмийн үйл ажиллагааны талаар 2 видео бичлэг YouTube дээр тавьсан. Үүний дараа Эв нэгдлийн сүмийг шүүмжлэгч Э.Цэрэндолгор Авлигатай тэмцэх газрыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны нэгэн газрын даргыг Монголчуудын тархийг угааж мөн Эв нэгдлийн сүмийн мөнгийг угааж байгааг шалгах хүсэлт тавьсан. Гурван өдрийн дараа тухайн хүн утас, Facebook, Twitter зэргээр дарамтлуулсан гэдэг шалтгаанаар ажлаа хүлээлгэж өгөх өргөдлөө өгөхийн хамт цагдаад энэ хэргийг шалгуулахаар хандсан. Гэвч тэрээр ажлаа хүлээлгэж өгөхөө больсон”⁸ (2016). “Христийн болон бусад шашны цөөнхийн эсрэг хэвлэл, мэдээлэл ба нийгмийн сүлжээгээр дарамталсан мэдээлэл байна. Жишээ нь, нэгэн ерөнхийлөгчид нэр дэвшигчийн сүмийн гишүүдтэй авахуулсан зураг сонгуулийн сурталчилгааны үеэр цахим сүлжээнд гарснаас болж Дэлхийн энх тайван, эв нэгдлийн төлөөх гэр бүлийн холбоо сүмийнхний талаар сөрөг сэтгэгдлүүд интернетээр гарсан.

¹ Мөн тэнд

² <https://mn.usembassy.gov/our-relationship/official-reports/2016-international-religious-freedom-report/>

³ Мөн тэнд

⁴ <https://mn.usembassy.gov/our-relationship/official-reports/2017-international-religious-freedom-report/>

⁵ <https://mn.usembassy.gov/our-relationship/official-reports/2018-international-religious-freedom-report/>

⁶ <https://mn.usembassy.gov/our-relationship/official-reports/2015-international-religious-freedom-report/>

⁷ <https://mn.usembassy.gov/our-relationship/official-reports/2016-international-religious-freedom-report/>

⁸ Мөн тэнд

МЭЭ-ийн үзэж буйгаар олон нийт шашны эрх чөлөөг илүү дэмждэг болсон. Өмнөх жилүүдийг бодвол энэ жил будда болон мусульман шашны тэргүүнүүд христийн шашны нөлөө давамгайлах байдалд санаа зовнисон байр суурь илэрхийлээгүй. Гэхдээ зарим христийн шашныхан олон нийт христийн шашны нөлөө ихэсч байгаад дургүй байдаг нь хэвээр ба ялгаварлан гадуурхал байгаа гэж хэлж байв... гэхдээ зарим христийн шашныхан олон нийт христийн шашны нөлөө ихэсч байгаад дургүй байдаг нь хэвээр ба ялгаварлан гадуурхал байгаа гэж хэлж байв¹ (2017) гэх зэргээр дурджээ.

Тайлангийн IV хэсэг буюу АНУ-ын Засгийн газрын бодлогын талаар: Тайлангуудад АНУ-ын ЭСЯ-аас жил бүр “...Шашны эрх чөлөөг хүндэтгэх, хүлээцтэй байдлыг дэмжих үүднээс өөрсдийн зохион байгуулдаг арга хэмжээнд Будда, Христ, Мусульман, Бөө зэрэг шашны удирдагчдыг урьж оролцуулдаг”² (2015).

АНУ-ын засгийн газраас ивээн тэтгэдэг зочны хөтөлбөрийн дагуу Америкийн мусульман шашны эрдэмтэн 2-р сард зочилж, төв, орон нутгийн удирдагчид, шашны тэргүүнүүд, иргэний нийгмийн төлөөлүүд болон казах түмэнтэй уулзаж, шашин хоорондын, төр шашин хоорондын харилцан ярианы чухлыг онцлон ярьсан. Эрдэмтэн маань мөн сүм хийдүүд, шашны сургуулиудыг шашны хүлцэл, шашин хоорондын харилцааны үнэ цэнийн талаар яриа өрнүүлж байхыг уриалж байлаа”³ (2016) хэмээсэн байна.

АНУ-ын Элчин сайд болон засгийн газрын бусад албан тушаалтнууд шашны эрх чөлөөний асуудлаар, визтэй холбоотой хууль тогтоомж тэгш бус хэрэгжиж байгаа талаар, мөн шашны бүлгүүдийн тоочдог бүртгүүлэхэд учирдаг бэрхшээл зэрэг АНУ-ын засгийн газрын зовинож буй асуудлын талаар засгийн газрын албан тушаалтнуудтай орон нутаг, аймаг, улсын түвшинд, Дархан-Уул, Ховд, Увс аймагт ажиллахдаа ярилцсан болно⁴ (2017).

Мөн “АНУ-ын олон улсын шашны эрх чөлөөний асуудал хариуцсан тусгай үүрэг гүйцэтгэгч элчин сайд гадаад хэргийн сайдтай уулзаж, шашны эрх чөлөөний талаарх хууль тогтоомжийг сайжруулах явдлыг дэмжсэн”⁵ (2018) ба “Монгол Улсын шашны эрх чөлөөний асуудал хариуцсан тусгай үүрэг гүйцэтгэгч элчин сайдтай шашны эрх чөлөөний асуудлаар тогтмол уулзаж, түүнийг АНУ-д олон улсын шашны эрх чөлөөний уулзалтуудад оролцох, ажил төрлийн холбоогоо өргөжүүлэхэд нь тусалсан”⁶ (2018) байна. АНУ-ын Төрийн департамент шашны эрх чөлөөний хуулийн төсөлд олон нийтээс санал авах хугацаанд өөрийн саналыг хүргүүлсэн⁷ юм байна.

Ийнхүү АНУ-ын төрийн департаментаас Монгол Улсын шашны эрх чөлөөний нөхцөл байдалд шинжилгээ хийж жил бүр Монгол Улс дахь АНУ-ын Элчин сайдын яамны цахим хуудсаар олон нийтэд нээлттэй тайлагнаж байна.

Тайлан бүрд шашны байгууллагуудыг бүртгэх үйл явцын талаар бичдэг бөгөөд тухайлбал, 2018 оны тайланд “Дотоодын хууль тогтоомжид шашны байгууллагын бүртгэлийн журамтай холбоотой нарийвчилсан заалт бараг тусгаагүй, бүртгэлийн хүчинтэй хугацааг хэрхэн тогтоохыг заагаагүй ба орон нутгийн эрх баригчид өөрсдөө

¹ <https://mn.usembassy.gov/our-relationship/official-reports/2017-international-religious-freedom-report/>

² <https://mn.usembassy.gov/our-relationship/official-reports/2015-international-religious-freedom-report/>

³ <https://mn.usembassy.gov/our-relationship/official-reports/2016-international-religious-freedom-report/>

⁴ <https://mn.usembassy.gov/our-relationship/official-reports/2017-international-religious-freedom-report/>

⁵ <https://mn.usembassy.gov/our-relationship/official-reports/2018-international-religious-freedom-report/>

⁶ <https://mn.usembassy.gov/our-relationship/official-reports/2018-international-religious-freedom-report/>

⁷ <https://mn.usembassy.gov/our-relationship/official-reports/2018-international-religious-freedom-report/>

журам боловсруулах эрх мэдэлтэй байдаг. Бүртгэлээ сунгуулахдаа шашны байгууллагууд (ихэнх тохиолдолд жил бүр) орон нутаг болон улсын түвшний төрийн олон байгууллагад хандах ёстой байдаг” хэмээжээ.

Мөн тэнд “...Эрүүгийн хуульд зааснаар, хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, шашны байгууллагын үйл ажиллагаа, эсхүл шашны зан үйл үйлдэхэд саад учруулсан бол хувь хүнийг 450,000– 2,700,000 төгрөгөөр торгох, эсхүл 240-720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл 1-6 сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ¹. Хэрвээ шашны байгууллага, номлогч, лам, имам, бөө зэрэг шашны төлөөлөгч өөрийн шашны үзэл номлолоо бусдад хүчээр тулгасан, шахалт үзүүлсэн, хууран мэхэлж татан оруулсан, эсхүл шашны харгис үзэл номлолыг сурталчилсан бол 450,000-5,400,000 төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ². Зөрчлийн тухай хуульд зааснаар, хүүхдийн хүсэл зоригийн эсрэг шашны үйл ажиллагаанд татан оролцуулсан бол хүнийг 100,000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 1,000,000 төгрөгөөр торгоно³. Иргэний шашин шүтлэгийн байдлыг уг хүн өөрөө хүссэнээс бусад тохиолдолд албан баримт бичигт тусгасан, эсхүл хуульд зааснаас бусад тохиолдолд сүм хийдийн дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцсон бол хүнийг 100,000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 1,000,000 төгрөгөөр торгоно. Шашны байгууллага төрийн байгууллагын үүргийг эрхлэн гүйцэтгэсэн, улс төрийн үйл ажиллагаа явуулсан, эсхүл түүнд оролцсон, эсхүл санхүүжүүлсэн бол хүнийг 150,000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 1,500,000 төгрөгөөр торгоно. Төрийн харьяалал бүхий сургууль, байгууллагад шашны сургалт, цугларалт зохион байгуулсан бол хүнийг 300,000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 3,000,000 төгрөгөөр торгоно⁴.

¹ Эрүүгийн хуулийн (14 дүгээр бүлэг Хүний хувийн эрх, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг, 4 дүгээр зүйл Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хэрэгжүүлэхэд саад учруулах) 14.4.1-д: Хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулахаар сүрдүүлж шашны байгууллагын үйл ажиллагаа, эсхүл шашны зан үйл үйлдэхэд саад учруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

Эрүүгийн хуулийг 2015 онд шинэчилэн найруулсан ба энэ заалтад 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар ийнхүү өөрчлөлт оруулжээ.

² Эрүүгийн хуулийн 14.4.2-т: Шашны байгууллага, шашны төлөөлөгч, номлол түгээгч өөрийн шашны үзэл номлолоо бусдад хүчээр тулгасан, шахалт үзүүлсэн, хууран мэхэлж татан оруулсан, эсхүл шашны харгис үзэл номлолыг сурталчилсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Энэ заалтыг 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар ийнхүү өөрчилөн найруулсан байна.

³ Зөрчлийн тухай хуулийн (Хүүхдийн эрхийг зөрчих) 6.20.4-т: Хүүхдийн хүсэл зоригийн эсрэг шашны үйл ажиллагаанд татан оролцуулсан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

⁴ Мөн хуулийн (Төр сүм хийдийн харилцааны тухай хууль зөрчих) 15.22-т:

1. Иргэний шашин шүтлэгийн байдлыг уг хүн өөрөө хүссэнээс бусад тохиолдолд албан баримт бичигт тусгасан, эсхүл хуульд зааснаас бусад тохиолдолд сүм хийдийн дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцсон бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Сүм хийдээс:

2.1. төрийн байгууллагын үүргийг эрхлэн гүйцэтгэсэн;

Төр, сүм хийдийн харилцааны хуулинд шашны үзэл номлолыг “хүчээр тулгах, шахалт үзүүлэх, эд мөнгөөр татах, хууран мэхлэх, тэдний эрүүл мэнд, ёс суртахуунд хохирол учруулах, санаа сэтгэлийг үймүүлэх замаар” дэлгэрүүлэхийг хориглодог. Мөн шашинд татан оруулахын тулд бэлэг сэлт ашиглахыг хориглодог¹. Хүүхдийн эрхийн тухай хуульд хүүхэд шашин шүтэх, эс шүтэх эрхтэй гэж заасан².

Уг хуулиар шашны байгууллага Монголын ард түмний уламжлал, зан заншилд харшлах болон хүмүүнлэг бус үйл ажиллагаа явуулахыг хориглодог” хэмээн Монгол Улсад шашин, шашин шүтлэгтэй холбогдсон хориотой үйлдлүүдийг хууль эрх зүйн бодлогын баримт бичгүүдэд үндэслэн бичсэн байдаг юм.

Олон улсын шашны эрх чөлөөний тайлангийн агуулгаас үзвэл:

1. Монгол улс дахь төр, шашны харилцааны эрх зүйн зохицуулалтад анхаарч, ялангуяа “Төр сүм хийдийн харицааны тухай хууль”-ийг хэрэгжүүлэх явцад үүссэн асуудлуудын талаар өөрсдийн олсон мэдээлэлд үндэслэн бичсэн байна. Ингэхдээ шашны институцийг асуудлын төвд тавьдаг;
2. Монгол улс дахь төр, сүм хийдийн харилцааг зохицуулсан хууль, тогтоомжийн хэрэгжилтэд сүм хийдийн бүртгэл, тэдний хугацаа сунгалт болон шашны виз авах асуудал сул байгааг онцолж буй.
3. Монгол улс дахь шашнуудын төлөөлөл, шашны байгууллагуудын тэргүүдтэй тогтмол уулзалт зохион байгуулж тэдэнд учирч буй асуудлууд, шашны эрх чөлөөний байдлын талаар санал солилцдог байна.;
4. Төрийн байгууллагууд болон төрийн албан хаагчидтай шашны асуудлаар тогтмол уулздаг;
5. Төр болон шашны байгууллагуудын харилцааны зарим нь санхүүгийн харилцаа байдаг бөгөөд тухайлбал, “орон нутгийн төрийн захиргааны байгууллага санхүүгийн чадавхтай шашны байгууллагаас тусламж хүсдэг” хэмээсэн нь анхаарал татаж байна;
6. Тайланд төр, шашны тэргүүдийн уулзалт, ялангуяа төрийн өндөр дээд албан тушаалтнууд болон Бурханы шашинтнуудын харилцааг онцлон тэмдэглэж иржээ.

2.2.төрийн эрх мэдлийн төлөө улс төрийн үйл ажиллагаа явуулсан, эсхүл түүнд оролцсон, эсхүл санхүүжүүлсэн бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3. Төрийн харьяалал бүхий сургууль, байгууллагад шашны сургалт, цугларалт зохион байгуулсан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Тайлбар: Төрийн харьяалал бүхий сургууль, байгууллагад шашны сургалт, цугларалт зохион байгуулах нь шашны соёл, мэдлэг ухааны өв уламжлалын тухай шинжлэх ухааны сургалтад үл хамаарна гэж УИХ-аас 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдөр баталсан Зөрчлийн тухай хуулийн шинэчлэн найруулгад заажээ.

¹ Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн (3 дугаар бүлэг Шашны байгууллагын тухай, 7 дугаар зүйл Сүм хийд, лам санваартны үйл ажиллагааны эрх зүйн үндэс) 7.7-д: Аливаа шашны байгууллага, лам санваартан өөрийн шашныг эс шүтэгчдэд үзэл бодлоо хүчээр тулгах, шахалт үзүүлэх, эд мөнгөөр татах, хууран мэхлэх, тэдний эрүүл мэнд, ёс суртахуунд хохирол учруулах, санаа сэтгэлийг үймүүлэхийг хориглоно.

² Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн (Хүүхдийн хөгжих эрх) 6.1.4-т: Хүүхэд шашин шүтэх, эс шүтэх эрхтэй-г заажээ. Тус хууль 2016 онд батлагдаж мөн оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдсөн болно.

Америкийн Нэгдсэн Улсын Төрийн Департаментаас гаргадаг Олон улсын шашны эрх чөлөөний Монгол Улсад хамаарах тайлангийн талаар манайд урьд өмнө ямар нэгэн үнэлэлт, дүгнэлт өгсөн зүйл байхгүй бололтой.

НОМ ЗҮЙ

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Монгол Улсын Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль
3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль
4. Монгол Улсын Их Хурлын тухай хууль
5. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль
6. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
7. Ард нийтийн санал асуулгын тухай хууль
8. Төрийн албаны тухай хууль
9. Хөдөлмөрийн тухай хууль
10. Зөрчлийн тухай хууль
11. Монгол Улсын Эрүүгийн хууль
12. Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албаны тухай эрх зүйн байдлын тухай хууль
13. Онц байдлын тухай хууль
14. Монгол Улсын Иргэний хууль
15. Улсын бүртгэлийн тухай хууль
16. Соёлын тухай хууль
17. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль.
18. Боловсролын тухай хууль

Цахим эх сурвалж:

1. <http://www.pewresearch.org>
2. <https://religionunplugged.com/news/2019/6/21/five-takeaways-from-the-2018-international-religious-freedom-report>
3. https://www.chinadaily.com.cn/china/2015-10/15/content_22199438.htm
4. <https://www.hurriyetdailynews.com/turkey-slams-us-report-on-religious-freedom-132643>
5. https://www.xinhuanet.com/english/2019-06/29/c_138183172.htm
6. <https://www.timesofisrael.com/israel-pushes-back-on-us-report-spotlighting-religious-freedom-woes/>
7. <https://www.millenniumpost.in/world/china-iran-reject-us-religious-freedom-report-as-hypocritical-257749>
8. www.1212.mn
9. <https://mn.usembassy.gov/our-relationship/official-reports/2018-international-religious-freedom-report/>
10. <https://mn.usembassy.gov/mn/our-relationship-mn/official-reports-mn/2016-international-religious-freedom-report-mn/>

11. <https://mn.usembassy.gov/mn/our-relationship-mn/official-reports-mn/2017-international-religious-freedom-report-mn/>
12. <https://mn.usembassy.gov/our-relationship/official-reports/2018-international-religious-freedom-report/>

ABSTRACT

Religion is a phenomenon that has served as a social, cultural and psychological functions for humankind for long periods of time- thus, in essence it should be common and widespread and easily defined. However, in its long history of development, religion has become too vague and ambiguous to define, too sensitive and wide and multi-faceted in some ways. Therefore, many countries tend to set out a systematic and predictive religious environment and establish a connection between state and religious institutions (monasteries), while allowing a freedom of religious believe.

In Mongolia, the right to freedom of religious beliefs is not suspended during the state of war and emergency. Freedom of religious believe is one of the basic and indispensable human rights in Mongolia and there are roughly about 70 different religions, which operate without any restrictions. This proves that Mongolia is one of a few countries that have the most freedom of religion and faith.

Countries have been paying a close attention to issues relating to religious belief, and exercise rights to freedom of speech regarding religion and belief.

The USA promotes religious freedom around the world and in 1998 declared international religious freedom act. Since then the USA has been publishing a public annual report on a detailed account of status of religious freedom in many countries under the official title of “International Religious Freedom Report”. This also includes the report on the state and factual accounts of religious freedom in Mongolia, namely 2015, 2016, 2017, and 2018 annual reports on Mongolian religious freedom.